

ПУЛИТЦЕР, ХЁРСТ БА «ШИНЭ СЭТГҮҮЛ ЗҮЙ»

Ц. Чойсамба*

* МУИС, НУФ, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, дэд доктор, дэд профессор

1. Жозеф Пулитцер

Америкийн сонины магнат, «хэвлэлийн хаан» Жозеф Пулитцерийн (Joseph Pulitzer) дүр үе үеийн сэтгүүлч, судлаач, зохиолчдын сонирхлыг татсаар ирсэн юм. Америкийн нийгмийн доод шатнаас эхлээд түүний оргилд нь гарталх урт замыг туулж, үгээгүй хоосноос үлэмж саятан болтол замнасан тэрээр «Америк мөрөөдөл»-ийн бодит биелэл байсан аж.

Сэтгүүл зүй рүү хийсэн алхам

Жозеф Пулитцер 1847 оны 4-р сарын 10-нд Унгарын нийслэл Будапешт хотноо чинээлэг гэр бүлд мэндэлжээ. Эрэмдэг эцэгтэй Жозеф бие султай төрж, бүхий л насаараа элдвийн өвчин эмгэгээс шаналж байв. Гэвч нөгөө талаар эрүүл мэндийн байдал нь Жозефд өөрийгөө төгс дайчлах, бэрхшээлийг үл хайхран гэтлэх хосгүй чадварыг суулгасан нь хожим юу юунаас илүү хэрэг болжээ. Цэл залуугаараа өтгөс

буурал шиг эрүүл мэндтэй болсон тэрээр аз туршсан, амь өрсөн адал явдалд хутгалдах дуртай, нэг олдсон амьдралаа бахтай өнгөрөөнө гэсэн хатуу үзэлтэй байв.

17 настайдаа Пулитцер эцгийнхээ гэрээс зугтан тэнүүчилж байхдаа АНУ-ын армийн Европ дахь төлөөлөгчтэй учирч, сэтгэлийн хөөрлөөр сайн дурынханд нэгдэж, Ерөнхийлөгч Авраам Линкольны цэрэгт элсэж, Шинэ ертөнцийг зорьжээ. Нью-Йоркд ирээд, мажаар залуу морин цэргийн хороонд бүртгүүлж, боолчлолын ёсыг улайран хамгаалж байсан Өмнөт мужуудын эсрэг дайтах болжээ. Армийн харгис дэг, цэргийн амьдралын ачаа залуухан Пулитцерт хэт ахдаж, тэрээр насан туршдаа дайныг тууштай жигших болов. 1865 онд Иргэний дайн Өмнөт мужуудын ялагдлаар төгсөхөд, Пулитцер Нью-Йоркд эргэн ирж, ажил хайн, хотын гудамжаар гутлаа элэгдтэл хэсүүчлэв.

Аварга Нью-Йоркийн бужигнасан амьдрал европ залууд тээртэй санагдаж, тэрээр Сент-Луис хотыг зорьжээ. Тэнд Жозеф луус хариулж, боомтод ачигч хийж, усан онгоц дээр тэнгисийн цэргийн

дагалдангаар ажиллав. Чөлөө заваараа Пулитцер хотын номын санд сууж, өдөржин суудлаасаа босолгүй уншиж, англи хэлний мэдлэгээ дээшлүүж байлаа. Хичээл зүтгэлтэй залуу төдөлгүй цагаачдыг төвхнүүлэх асуудлыг хариуцсан Германы байгууллагын нарийн бичгийн даргаар томилогджээ. Өөрөө цагаач учир Пулитцер Америкт шинэ амьдрал хайн ирсэн хүмүүсийн сэтгэл зүйг сайтар ойлгодог байв. Хожим тэрээр энэхүү мэдлэгээ «Нью-Йорк Уорлд» сониндоо ашиглажээ.

1868 онд Пулитцерыг герман хэлээр хэвлэгддэг «Вестлише Пост» сонин сурвалжлагчаар авчээ. Пулитцер өглөөний 10 цагаас шөнийн 2 цаг хүртэл ажилладаг байв. Хазгай англи хэлтэй, туранхай биендээ тохироогүй том толгойтой, царай муутай, хурц эрүүтэй түүнийг редакцийнхан анхандаа илэрхий элэг доог барьж, ажлаар дардаг байсан ч яваандаа ядрахыг мэддэггүй «электрон жаал»-ыг өөрийн эрхгүй хүндлэх болжээ. Чухам Пулитцер л сонины гол ачааг үүрч, түүний гараас гарсан хурц нийтлэлүүд нийгмийн амьдралын бузар булайг илчилж байв. Энэ үед олон нийтийн эрх ашгийг хамгаалсан сонин үгүйлэгдэж байгааг залуу сэтгүүлч ойлгожээ. «Вестлише пост» сонины удирдлага ч Пулитцерыг бүрэн дэмжиж байв.

1872 оны сонгуулийн үеэр «Вестлише пост» либерал-бүгд найрамдах намын эвслийг дэмжиж, Пулитцер нэр дэвшигчдийг нь үг хайрлалгүй сурталчилсан ч эвсэл амжилтанд хүрээгүй байна. Энэ нь «Вестлише пост»-од шууд нөлөөлж, уншигчдын хүрээ хумигдаж, дампуурлын ирмэгт тулахад, хөдөлмөрийн

хөлсөө 4 жил хуримтлуулсан Пулитцер сониныхоо тал хувьцааг хямд үнээр худалдан авчээ. Гэвч сонины удирдлага Пулитцерын ажлын хурдыг гүйцэхгүй, түүнээс хувьцааг нь эргүүлэн худалдаж авсан байна.

30 мянган доллар (тэр үеийн 1 америк доллар манай одоогийн ханшаар 4000 орчим төгрөгтэй тэнцэнэ) «унагасан» туршлагатай сэтгүүлч Жозеф хоёр жил Европоор аялаад, Сент-Луисд эргэн ирж, 1878 оны 12-р сард сонины эрхлэгч болжээ. Орлого багатай «Сент-Луис Диспетч» сониныг үнэ хаялцуулах худалдаанаас 2500 доллараар авч, 30 мянгын хөрөнгө оруулалт хийжээ. Үлдсэн 2700 доллараар сониноо хөдөлгөж эхэлсэн Ассошиэйтэд Пресс агентлагийн гишүүн Пулитцер гурав хоногийн дараа тус агентлагийн мэдээллийг үгүйлж байсан «Вестлише Пост»-ын эрхлэгч Жон Диллонтой нэгдэж, «Пост-Диспетч» нэрээр сониноо гаргах болов.

Хэрэв Америкийн хэвлэл мэдээллийн зах зээл дээр 1860-аад онд толгой цохиж байсан Чарльз Данагийн «Нью-Йорк сан» сонин хөрөнгөтний эрх ашгийг хамгаалж байсан бол Пулитцер алдарт: «Publicity. Publicity. Publicity.» («Ил тод байдал. Ил тод байдал. Ил тод байдал.») үгээ хэлж, өөрийгөө энгийн ардын хүсэл эрмэлзлийн индэр хэмээн зарлаж, дээдсийн зиндааныхныг халз тулаанд дууджээ. Гоц ухаан, сэтгүүлчийн ур чадвар, цуцашгүй хөдөлмөрч чанар, менежерийн ховор авьяасыг сульдаатай биендээ хослуулж чадсан Пулитцер энэ бодлогоо тууштай баримталснаар тухайн үеийн хамгийн өргөн аудиторийг өөртөө татаж чадсан юм.

удалгүй Сент-Луис хотын иргэд «Пост-Диспэтч»-ийг «бидний сонин» хэмээн хүлээн зөвшөөрөв. Хэсэг хугацааны дараа Пулитцер Диллоноос хувьцааг худалдан авч, сониноо дангаараа эрхлэх болж, авьяаслаг сэтгүүлчдийг татаж, багаа бүрдүүлж эхлэв.

Жон Кокрилл гэдэг чадварлаг сэтгүүлч ирснээр Пулитцерийн сонины борлуулалт улам нэмэгдсэн байна. Сент-Луисын оройн сонинуудын лидер болсон «Пост-Диспэтч» томчуудын заль луйврыг илчилж, жижиг аж ахуйтан, ажилчин, дундад ангийнхны эрх ашгийг тууштай хамгаалахын зэрэгцээ гэмт хэргийн материалыг нийтэлж байв. Сент-Луис Пулитцерийн хувьд туршилтын талбар байсан юм. Хожим сая саяар

хэвлэгддэг сониноо босгоход энэ үеийн туршлага Пулитцерт хамгийн их хэрэг болжээ. «Пост-Диспэтч» жилд 40-50 мянган долларын ашиг өгөх болов. Нэг бизнесмен сониноо 1,6 сая доллараар худалдахыг санал болгосон ч Пулитцер зөвшөөрөөгүй байна.

Пулитцер дөнгөж 35 нас хүрсэн ч эрүүл мэндийн байдал нь түгшүүрийн дохио өгөх болж, тэрээр хэдэн цагаар босдоггүй суудлаа орхиж, эрс тэс уур амьсгалтай Миссури мужийг орхихоос өөр аргагүйд хүрэв. Ингээд Жозеф дахиад л далайн зөөлөн уур амьсгалтай Нью-Йоркд ирсэн байна. Үүнд өөр шалтгаан

нөлөөлсөн нь «Нью-Йорк геральд» сонинд ажилладаг дүү Альберт нь 25 мянган долларын хөрөнгөтэй «Морнинг Жорнэл»-ыг эрхлэн гаргах болсон явдал байв. Нэг центээр худалдагддаг энэ сонин анхнаасаа борлуулалт сайтай байжээ.

Нью-Йоркд

Жозеф Пенсильванийн төмөр замын эздийн нэг, бизнесмен Жей Гаулдын «Нью-Йорк Уорлд» сониныг худалдан авахаар шийджээ. «Уорлд» жил бүр 40 мянгын алдалтай гарч, уншигчдын тоо нь өдрөөс өдөрт цөөрч байв. Хэдэн сая хүн амтай Нью-Йоркд ард түмэнд хандсан, тэднийг дэмжсэн сониныг зөв эрхэлвэл жижиг Сент-Луисийг бодвол галзуу ашиг олохыг тоо

цоолсон Пулитцер 346 мянгаар «Уорлд»-ын эрхийг авав. Нью-Йоркд хэд хэдэн өдрийн сонин хэвлэгддэгээс эмээлгүй Пулитцер ажилдаа оров. Хотын хүн амтай нийт сонины нэг удаагийн гаралтын тоог харьцуулахад өчүүхэн тул хичнээн агуу том зах зээл байгааг Пулитцер ойлгож байлаа.

Ажлын эхний өдөр «Уорлд»-ын нойрмог редакцийг ирээдүйн магнат донсолгов. Бэлэн материалыг дахин засч, сэтгүүлч, сурвалжлагч нарт зааварчилж, нэгдүгээр нүүрийг өөрөө макетлаж, түүгээр ч үл барам завсар зайнд нь редакцийн өгүүллийг бичив.

1883 оны 5-р сарын 11-нд бичсэн зарчмаа Пулитцер насан туршдаа баримталжээ. Тэрээр: «Цэцэглэн хөгжиж буй энэхүү агуу том хотод зөвхөн хямдхан биш, бас цэцэн, зөвхөн цэцэн биш, бас өргөн хүрээг хамарсан, зөвхөн өргөн хүрээг хамарсан биш, бас жинхэнэ ардчилсан, мөнгөний туламнуудын биш, ард түмний талын, луйвар залиг илчилсэн, нийгмийн сөрөг тал, дутагдлыг шүүмжилсэн сонин үгүйлэгдэж буй юм»¹ гэж бичжээ.

Долоо хоногийн дараа Пулитцер баячуудын тансаг хэрэглэлд татвар ногдуулахыг, ашиг хонжоо хайгч төрийн түшээ нарыг хатуу шийтгэхийг шаардсан эдийн засгийн хөтөлбөрөө дэвшүүлсэн байна. Өөрийгөө Пулитцер ардчиллын дуу хоолой, ардчиллын тунхагч хэмээн зарлав.

Сэтгүүлчийн үйл ажиллагаандаа Пулитцер баримталж байсан зарчим бол эхлээд олон нийтийн итгэлийг олж, борлогдох хувиа нэмээд, дараа нь ашиг, рекламн тухай бодох явдал байлаа. Тийм ч учир Пулитцер шуурхай мэдээлэлд ихээхэн ач холбогдол өгч байв. Гэмт хэрэг, секс цаг ямагт хүн төрөлхтний анхаарлыг татдагийг мэдсэн тэрээр эдгээр салбарт мөн л анхаарлаа хандуулж байлаа. «Уорлд»-ын сэтгүүлчид Америкийн өнцөг булан бүрт нэвтэрч, хамгийн хачин, хамгийн жигтэй, хамгийн ер бусын бүхнийг олж бичиж байв. Ямар нэг зэвүүцмээр гэмт хэрэг гарвал «Уорлд»-ын маргаашийн дугаар нь хэрэгтэн, хохирогчийн зурагтай, сэтгэл хөдөлгөсөн гарчигтай уншигчдын гар дээр очдог хуультай байсан аж. Зураг, гэрэл зураг нь анхандаа

нэг багана эзэлж байсан бол XIX зууны эцэс гэхэд 4-5 багана болтлоо томорчээ.

Пулитцерын санаачилсан «шинэ сэтгүүл зүй» («new journalism») эрч хүчээ авав. Хөхүүл хүү Жимээ нойрсож байхад нь хөнөөсөн галзуу эхийн тухай шилдэг нийтлэлчдийн бичсэн материал тэр үеийн Америкийн нийгэмд ёстой бөмбөг дэлбэлэх шиг болов. Гал усны аюул, байгалийн гамшиг, осол, аваар зэрэг нь «Уорлд»-ын тэргүүн нүүрний байнгын зочдын нэг болов. «Нью-Йорк геральд»-ын эрхлэгч Бенеттыг дагаад, Пулитцер спортын ертөнц дэх үйл явдлыг тусгаж эхлэв. Сониндоо спортын тусгай булан нээж, энгийн өдөр 3-4 багана, амралтын дуаарт бол бүтэн нүүрийг зориулна.

Пулитцерийн баг бол урьд өмнө байгаагүй шилдэг сэтгүүлчдийн цоморлиг байлаа. Шинэ, содон зүйл олж бичихийн тулд тэд яахаас ч үл буцна. Нэг нь шоронд орж, камерт хонож байхад, нөгөө нь галзуугийн эмнэлэгт хэвтэж, ямар ч сэтгүүлчийн харахгүйг харж, сонсохгүйг сонсоно. «Нью-Йорк геральд»-ын суурийг нь тавьсан адал явдалт сэтгүүл зүй («stunt journalism») сонгодог утгаараа «Уорлд»-д биеллээ олов.

Пулитцер сониныхоо зураг дүрс-лэлд ихээхэн анхаарал тавьж байлаа. Өдөр тутмын анхны зурагт сонин «Дэйли Грэфик»-ийн ололт амжилтыг тэрээр өргөн ашиглаж, Оросын авьяаслаг зураач Валериан Грибоедовыг ажилдаа авчээ. Грибоедов гэрэл зургийг хуулбарлан зурснаар «Уорлд»-ын дугаар болгоны 1-р нүүрний баруун дээд буланд улс төрч, баячууд, гэмт хэрэгтэн, хулгайч, алуурчин гэх мэт

«мэдээг бий болгогчид»-ын хөрөг гарах болжээ. Үүний ачаар «Уорлд»-ын хэвлэгдэх хувь эрс өсөв. Анх удаа сэтгүүл зүйд зургийг ийм тодорхой зорилгоор ашиглав. Ер нь «Уорлд» зургийн тал дээр техникийн бүхий л дэвшлийг өргөн ашигладаг байсныг онцлох хэрэгтэй. Түүнээс гадна «Уорлд» улс төрчдийн шог зургийг нийтэлдэг анхны өглөөний сонин болжээ. Үдшийн сонин дотроос Беннет эрхлэгчтэй «Ивнинг телеграмм» үүнийг «Уорлд»-оос түрүүн хэрэгжүүлсэн байна. «Пак» сэтгүүлд ажиллаж байхдаа алдаршсан шог зураач Уолт Мак-Дагалл Грибоедовын хамт 1884 оны сонгуулийн компанит ажлын үеэр цуврал шог зураг нийтлүүлсэн нь уншигчдын таашаалд ихэд нийцжээ.

Пулитцерын гарт «Уорлд» илчлэн шүүмжлэх агуу том хэрэгсэл болж чадсан байна. Гэвч түүнээс өмнө «Нью-Йорк таймс» сонин Твидийн бүлэглэлийн булхайг илчилж байснаас үзвэл Пулитцер энэ салбарт мөн л анхдагч биш байжээ. Гэхдээ түрүүлж гарсан чихнээс хожуу ургасан эвэр урт гэгчээр «Уорлд»-ын эзэн нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралын бүхий л салбарт нэвтрэн орж, дээр дооргүй шүүмжилж эхлэв. Өдөр тутмын ажил, зовнилдоо дарагдсан нь-ю-йоркчуудыг гүн нойрноос нь сэрээхийн тулд Пулитцер: «Манай сонин бол жинхэнэ ард түмний, тэдний эрх ашгийг хамгаалсан сонин» гэж тунхаглажээ.

Хамгийн түрүүнд Нью-Йоркийн төмөр замын магнат Жейкоб Шарп «Уорлд»-ын бүхнийг «шатаан ариусгагч» галд өртөж, шоронд оров. Тэрээр ашигтай гэрээ байгуулахын тулд Бродвейн дагуух хүн

амын саналыг худалдан авахаар шийдэж, Нью-Йоркийн захиргааны гишүүн бүрийн гарыг 25 мянган доллараар хүндрүүлэхийг зэхэж, хотын хууль тогтоогчдод ихээхэн мөнгө өгсөн байжээ. «Уорлд» тэдний эсрэг загалмайтны дайн зарлаж, олон нийтийг дагуулж чадсанаар, Шарп болон түүнтэй харьцаанд орсон томчуул бүр эрүүгийн хариуцлагад татагдсан байна.

Пулитцерын шүүмжлэлд өртөөгүй монополь гэж байсангүй. Гэхдээ Ж.П.Морган энд Компэнигийн эсрэг явуулсан илчлэх ажил хамгийн их шуугиан дэгдээжээ. 1895 оны 2-р сард АНУ-ын засгийн газар 60 сая долларын үнэ бүхий төрийн зээлийн бон гаргасныг бүгдийг нь Ж.Морган худалдаж аваад, ашигтай дамлан худалджээ. Мөн оны 12-р сард Засгийн газар 100 сая долларын бон гаргахаар төлөвлөснийг «Уорлд» мэдэж, тэдгээрийг Морганаар дамжуулалгүй шууд худалдаалахыг Санхүүгийн департамент (АНУ-ын санхүүгийн яам)-аас уриалж, АНУ-ын бүх банканд арван мянган цахилгаан илгээсэн байна. Аргагүйн эрхэнд АНУ-ын санхүүгийн төрийн нарийн бичгийн дарга Жон Карлайл боны чөлөөт худалдааг зарласнаар ард түмэнд өмнөхөөсөө хямд үнээр авах боломж бүрджээ. 1896 оны 1-р сарын 6-нд «Уорлд» тэргүүн нүүрэндээ «Синдикатыг унагав!» гэсэн том гарчигтай хэвлэгджээ. Пулитцер ч өөрөө ард түмний эрх ашгийг хамгаалагчаар энэхүү компанит ажлыг эхлээд түрийвчээ 50 мянган доллараар зузаатгав. Тэрбээр ийм аргаар сониныхоо ашгаас гадуур давхар орлого олдог байжээ.

Дээдсийнхний бузар булхайг илчлэхийн зэрэгцээ «Уорлд» ажилчин ангийн индэр болж, үйлдвэрчний эвлэлүүдийг дэмжиж, ажилчдын сэдвийг өргөн тусгаж байв. «Уорлд» 8 цагийн ажлын өдөр, бямба гаригийн богиносгосон ажлын өдөр, 7 хоног тутмын цалингийн төлөө шаргуу тэмцэж байлаа. Тэр үед Америкийн ажилчид гол төлөв цалингаа сард нэг удаа авдаг байснаас бүтэн сарын турш өртэй явдаг байжээ.

Энгийн ардад хийсэн Пулитцерын өөр нэг тус бол Бруклинг Манхеттэнтэй холбосон гүүрийг хүмүүст үнэгүй ашиглуулах болсон явдал байв. Асар их зардлаар боссон энэ гүүрийг Нью-Йоркийн удирдлага хотын иргэдэд төлбөртэй ашиглуулах бодолтой байсан ч «Уорлд»-ын давшилтан доор арга буюу буулт хийжээ. Ингэснээр бүгчим хороололд амьдардаг хүмүүс далайн зөөлөн амьсгалаар өдөртөө ганц ч болов удаа цээжээ дүүргэх болов.

«Уорлд» сонин хотын бус, үндэсний хэмжээнд 1885 онд хүлээн зөвшөөрөгдсөн юм. Бүгд Найрамдах Франц улсын засгийн газраас бэлэглэсэн уран барималч Бартольдигийн Эрх чөлөөний хөшөөг конгресс хөрөнгө мөнгөгүйгээс босгож чадахгүй бүхэл бүтэн есөн жилийн нүүрийг үзжээ. Аварга том хөшөөг сүндэрлүүлэхийн тулд түүнтэй дүйх суурь хэрэгтэй байв. Цагаач Пулит-

цер америкчуудад төдийгүй, аз жаргал хайн шинээр ирэгсдэд хүртэл энэхүү хөшөө хичнээн ач холбогдолтой, билэг дэмбэрэлтэйг соргог мэдэрч, ээлжит кампанит ажлаа эхэлжээ. Гуталчин, сонин борлуулагч, ажилчин, гуйлгачин, зөөгч, оёдолчин, хөгшин залуу, янхан, хулгайчгүй, эрэгтэй эмэгтэй, итали, хятад, еврей, польш бүгд чадлынхаа хэмжээгээр мөнгө хандивлав. Зуун мянган доллараар боссон Эрх чөлөөний хөшөө Нью-Йоркийн буланд орж буй онгоцуудыг угтан одоо ч сүндэрлэсээр байна.

Пулитцерийн ням гаригийн ертөнц

Амралтын өдрийн дугаарыг эрхлэн гаргагчийн хувьд Пулитцер тасархай байв. Хэрэв «Нью-Йорк Уорлд» ажлын өдөр дээд тал нь 24 нүүрээр гардаг байсан бол түүний дагуул амралтын дугаар «Санди Уорлд» нь 50 хүртэл нүүрээр (!) хэвлэгддэг байлаа. Талбайн талыг

«

*Цагаач Пулитцер
америкчуудад төдийгүй, аз
жаргал хайн шинээр ирэгсдэд
хүртэл энэхүү хөшөө хичнээн
ач холбогдолтой, билэг
дэмбэрэлтэйг соргог мэдэрч,
ээлжит кампанит ажлаа
эхэлжээ.*

»

реклам эзэлдэг байв. Ням гаригийн дугаараа Пулитцер жирийн дөрвөн сэтгүүлээс хавьгүй их унших материалтай гэж сурталчилна. «Санди Уорлд» үнэхээр сонирхолтой сонин болж чаджээ. Амралтын дугаарын давуу талыг (өдөр тутмын сонины дугаартай харьцуул-вал төлөвлөж болдог) Пулитцер гарамгай ашигласны үр дүнд 1884 оны 95 мянган

уншигч 1897 онд 600 мянга болтлоо нэмэгдсэн аж.

Авьяаслаг редакторууд Пулитцерын санаа оноог бүрэн хэрэгжүүлж чаджээ. Эмэгтэйчүүдийг анхандаа шог дүрсэлдэг байсан Пулитцер яваандаа ингэх нь ашиггүй, уншигчдаа алдаж байгааг ойлгож, сониноо бүсгүйчүүд, хүүхнүүдэд зориулсан хэд хэдэн тусгай булантай болгов.

Долоо хоног тутам Пулитцер уншигчдыг хөгжилтэй адал явдал, чөлөөт секс, хайр дурлалын түүх, дээдсийн амьдралын тухай нийтлэлээр угтах болов. Маш сонирхолтой бичигддэг байсан эдгээр материал амралтын өдөр өөрийгөө зугаацуулах юмаар хомс америкчуудыг хөгжөөж, тэдний хоосон орон зайг нөхөж чаджээ. Яваандаа «Санди Уорлд»-ын газар зүйн хэмжээ хүрээгээ тэлэв.

Аж үйлдвэрийн том хотынхны хувьд зэлүүд газар, мустанг, индианчууд, ковбойчуудын ахуй амьдрал, Египет, Турк, Хятад, Африкийн орнууд зэрэг экзотик газрын хүн амын тухай жигтэй материалууд ажилдаа нухлагдсан энгийн нь-Йоркчуудыг зугаацуулах төдийгүй, оюуны санд нь хандив болж байлаа.

«Уорлд» Нью-Йоркийн «Таймс», «Трибьюн» сонинуудын дараа шинжлэх ухааны сэдвийг тусгаж эхлэв. «Шинжлэх ухааны гайхамшгууд» буланг

Гаррет хөтөлж, уншигчдын дуртай булангуудын нэг болгожээ. Өөр нэг алдартай булан — «Итгэх эсэх нь таны дур»-ыг Роберт Рипли хөтөлж, долоо хоног тутам уншигчдад байгаль ертөнцийн сонин хачиныг өргөн барьж байв.

Тэр үед Америкийн шог зохиолчид хүчээ авахыг Пулитцер анзааралгүй өнгөрсөнгүй. Америкийн амьдралыг шоглон харуулдаг Билл Най анхандаа ганц баганатай байсан бол яваандаа өргөж-

сөөр тал нүүрийг «эээмших» болжээ. Спортын, залуучуудын сэдэв «Уорлд»-од мөн баттай байр суурь олжээ.

1893 онд

«Уорлд» анхны өнгөт зураг нийтлэх оролдлогыг хэрэгжүүлсэн байна. Зураач Р.Ауткот Хоугэн Элли хорооллын бяцхан хулигаануудын ахлагч

«

Тэрээр үүнийг цаг хугацааны асуудал гэж бодож байсан ч хүн төсөөлдөг, бурхан зохицуулдаг хойно амьдрал нь өөрөөр эргэв. Хэдхэн сарын дотор харахын буян тасарч, хүмүүс түүнийг ажлаа орхих нь гэж байлаа. Гэвч энэ удаад хүмүүс төсөөлж, Пулитцер зохицуулж, сэтгүүл зүйн үйл ажиллагаа, уран бүтээлийнхээ шинэ үед оров.

»

жаалыг тод шар цамцтай зурсан нь хожим «шар хэвлэл» («Yellow Press») хэмээх нэр томьёог үүсэхэд нөлөөлжээ. Ауткотыг хэвлэлийн өөр нэгэн магнат У.Р.Хёрст өндөр шагнал амлан ажилд авахад, «шар» цувралыг Жорж Лакс үргэлжлүүлсэн байна.

Мөн оны 11-р сарын 19-нд «Санди Уорлд» анхны өнгөт дугаараа уншигчдынхаа гар дээр тавьжээ. Харамсалтай нь Пулитцер энэ салбарт мөн л анхдагч биш байлаа. Үүнээс хоёр жилийн өмнө Чикаго

хотноо Х.Колсаат АНУ-ад анхны өнгөт сониныг хэвлэсэн ч хувь цөөтэй, ажиллагаа их шаарддаг тул олны хүртээл болж чадалгүй өнгөрчээ. 1893 онд Уолтер Скотт Компани нэг зэрэг 18 өнгөт нүүр хэвлэдэг төхөөрөмж бүтээснийг сонины ертөнцөд лидер байхыг хүсдэг Пулитцер асар өндөр үнээр «зодож» авчээ.

«The King of Press» буюу «Хэвлэлийн хаан» хэ-мээх эрхэм өргөмжлөлийг нөр их хөдөлмөрөөрөө хүртсэн Пулитцерын редакторын үйл ажиллагаа онцгой. Тэрээр сонины зүрх гэж үздэг нэгдүгээр нүүрээ өөрөө хянан засдаг байв. Эрүүл мэнд нь эрс муудсан үед ч Пулитцер захидал, цахилгаанаар зааварчилж, «Нью-Йорк Уорлд» хэмээх буухиа галт тэргийн эрчийг өчүүхэн ч алдуулаагүй юм.

АНУ-Испанийн дайн ба «Уорлд»

Пулитцер ардчилсан намыг тууштай дэмжиж байв. 1884 оны сонгуулиар «Уорлд» тус намаас нэр дэвшигч Гровер Кливлендыг дэмжиж, Нью-Йорк мужийг түүний араас дагуулж чаджээ. Кливленд Ерөнхийлөгч болсон хойноо Пулитцерын тусыг өндөр үнэлсэн байдаг.

Саад бэрхшээл хэвлэлийн хааныг насан туршид нь ороож байв. «Уорлд»-ыг худалдаж аваад, ердөө 4 жил хагасын дараа Пулитцерын эрүүл мэнд эрс муудаж, ажлын өрөөгөө орхиход хүрчээ. Тэрээр үүнийг цаг хугацааны асуудал гэж бодож байсан ч хүн төсөөлдөг, бурхан зохицуулдаг хойно амьдрал нь өөрөөр эргэв. Хэдхэн сарын дотор харахын буян тасарч, хүмүүс түүнийг ажлаа орхих нь гэж

байлаа. Гэвч энэ удаад хүмүүс төсөөлж, Пулитцер зохицуулж, сэтгүүл зүйн үйл ажиллагаа, уран бүтээлийнхээ шинэ үед оров. Амьдралын эрхээр анхны хараагүй эрхлэгч болсон Пулитцер Атлантын далайгаар аялах хувийн хөлгөөсөө, Европ, Америк дахь орд харшаасаа сониноо удирдаж байв. Хөлөг онгоцныхоо өрөөнөөс тэрээр редактор, сурвалжлагч нараа халж, тэдний оронд шинийг авч, шүүмжилж, шагнаж, зэмлэж, урамшуулж байлаа. Мөн тэр өрөөндөө Пулитцер нарийн бичгийн дарга нартайгаа уулзаж, «Уорлд»-ын багана бүрийг хэлэлцэж байв.

1888 онд Пулитцер манай редакци хуучин байшинд толгой хоргодох ёсгүй гэж үзээд, шинэ байшин бариулахаар шийджээ. 1889 оны 10-р сарын 10-нд суурь нь тавигдсан тус барилга 2,5 сая доллараар боссон байна. Нью-Йорк хотын хамгийн өндөр барилга болсон энэ байшинг 1890 оны 12-р сарын 10-нд сүр дуулиантайгаар албан ёсоор нээсэн байна. Нью-Йоркийн хамгийн өндөр, хамгийн том энэ барилга нь Пулитцерын өөрөө өөртөө, шинэ сэтгүүл зүйд зориулж босгосон хөшөө байлаа. Энэхүү тэнгэр баганадсан байшингийн дээр байрлуулсан алтадсан бөмбөгөр орой «Нью-Йорк Уорлд» ямар оргилд хүрснийг үгүй өгүүлж байв.

Тэр үед «Уорлд» сонины редакцид 12 мянган сэтгүүлч, хэвлэх үйлдвэрт 210 линотипчин буюу үсэг өрөгч, 60 стереотипчин буюу нүүр өрөгч хүчин зүтгэдэг байжээ. Хэвлэх үйлдвэрийнхэн 6 минутын дотор нүүрний стереотипийг, 35 минутанд

нэг зургийг бэлдэж байсан нь гайхалтай богино хугацаанд тооцогдож байлаа.

Энэ бүхнийг дагаад, сонины нэр хүнд өсөв. 15 мянган хувиар хэвлэгдэж байсан тус сониныг Пулитцер 15 жилийн дараа 800 мянган ширхэгт хүргэж чаджээ. Түүнээс гадна «Санди Уорлд» 700 мянган хувиар түгээгдэж байв.

1898 оны АНУ-Испанийн дайн дэгдэхэд Пулитцерын «Уорлд» Хёрстын «Морнинг Жорнэл»-ын адил онцгой үүрэг гүйцэтгэжээ. Буурал Европын гүрнүүдээс колоничлох бодлогоороо хол хоцорсон залуу Америк дайчин гадаад бодлого явуулахыг үндсэрхэг үзэлтнүүд шаардаж байлаа. «Уорлд», «Жорнэл» хоёр тэдний дуу хоолой болсон юм. Эдгээр сонины сурвалжлагчид испаничуудын Куба дахь (тэр үед Испанийн колони байсан) зэрлэглэл харгислалыг хэт дөвийлгөж, үг хайрлалгүй, нүдэнд үзэгдтэл бичиж байв. Гаваны боомтод Америкийн

«Мэн» хөлөг дэлбэрэхэд (шалтгаан нь тогтоогдоогүй) «Уорлд» испаничууд буруутайг манай сонины хөлсөлсөн хувийн мөрдөгчид тогтоолоо гээд (мэдээж, ямар ч мөрдөгчийг хөлслөөгүй), АНУ үүний хариуд Испаниас Куба арлыг салгаж, тэнд энх тайвныг тогтоох үүрэгтэй гэж тунхаглаж байлаа.

«Уорлд», ялангуяа «Жорнэл» америкчуудын сэтгэл зүйгээр тоглож, ерөнхийлөгч Уильям Мак-Кинли арга буюу олон нийтийн саналыг даган, Испанитай

дайтахаар шийджээ. 1898 оны 4-р сарын 17-нд «Уорлд»-ын ээлжит дугаар нэгдүгээр нүүрэндээ «Дайн зарлав» гэсэн том гарчигтай нийтлэгдэв. Сонины хувь 1,3 сая болж, рекорд тогтоов.

Пулитцер 1912 онд 65 настайдаа таалал төгсчээ. Сэтгүүлч мэргэжилгүй ч тэрээр сэтгүүл зүйн салбарт хүч сорьж, халаасандаа нэг ч центгүй, хазгай англи хэлтэй ч үзэг цаас нийлүүлж, эцэст нь 18 сая доллар хуримтлуулж чаджээ². Түүний гэрээслэлийг задлахад тэрээр Колумбын их сургуульд сэтгүүл зүйн салбар байгуулахад хоёр сая доллар хандивласнаа мэдэгдсэн байв. Амьдралдаа сэтгүүл зүйн

нэг ч лекц сонсоогүй Пулитцер сэтгүүлчдэд мэргэжлийн мэдлэг хэчнээн амин чухлыг хэнээс ч илүү мэдэж байлаа. Түүний мөнгөөр байгуулагдсан сэтгүүл зүйн салбар АНУ-д анхных байсан бөгөөд, өдгөө дэлхийд хамгийн шилдгүү-дийн

«
*Хэвлэлийн хаан өөрийгөө
сэтгүүл зүйд хувьсгал
хийсэн, бусад хэвлэн
нийтлэгчид түүнийг зөвхөн
хуулбарлан дууриагчид гээж
нэг удаа хэлжээ.*

»

тоонд ордог байна.

Өдгөө АНУ-ын сэтгүүлчдэд олгодог хамгийн хүндтэй шагнал Пулитцерийн нэрээр нэрлэгдсэн байдаг.

Пулитцерын өв

Хэвлэлийн хаан өөрийгөө сэтгүүл зүйд хувьсгал хийсэн, бусад хэвлэн нийтлэгчид түүнийг зөвхөн хуулбарлан дууриагчид гэж нэг удаа хэлжээ. Хэдийгээр Пулитцерын шинээр сэдсэн зүйл үгүй ч,

тэрээр бусдын сэдсэнийг хэрэгжүүлэхдээ гарамгай нэгэн байжээ.

Юуны түрүүнд Пулитцер Нью-Йоркд үйл ажиллагаагаа өрнүүлсэн эхний дөрөвхөн сарын дотор сонины эрхлэгчдийг өдөр тутмын дугаарын үнээ 4-өөс 2 цент, амралтын дугаарын үнээ 5-аас 3 цент болтол нь хямдруулахад хүргэжээ. Ингэснээр Пулитцер шинэ технологийн тусламжтайгаар сониныг илүү хямд үнээр уншигчдад хүргэх болсон байна. «Уорлд» маш ашигтай бизнес байсан бөгөөд, жил тутам эзэндээ цэвэр 500 мянган доллар өгч байжээ. Хэдийгээр Пулитцер сониноор бизнес хийж байсан ч дундад ангийнхны эрх ашгийг үнэхээр хамгаалагч байж чаджээ. Анх удаа сонин хэвлэл бодитойгоор дөрөв дэх засаглалын үүргийг гүйцэтгэв. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эх үндэс ч тавигдсан байна.

Пулитцерын «хаанчлал»-ын үед сонины зүс танигдахгүй болтлоо өөрчлөгдөв. Гарчиг улам томорч, сонины нүүрний макет өнгө оржээ (шууд ба шилжсэн утгаараа). Амралтын өдрийн дугаар нь шинэ уншигчдыг (эмэгтэйчүүд, залуучууд) шинэ булангуудаараа татаж чадсан байна.

2. Уильям Рэндольф Хёрст

Багшийгаа давж байж багш болдог гэсэн үг бий. Уильям Рэндольф Хёрст (William Randolph Hearst) эцгээ багш, хэвлэлийн магнат Жозеф Пулитцерийг иж бүрэн судлаад, хожим түүнийг давж гарч чаджээ.

Калифорнийн эхлэл

Уильям Рэндольф Хёрст 1863 оны 4-р сарын 20-нд Сан-Франциско хотноо төржээ. Дээдсийнхний амьдралаар амьдардаг, язгууртан гаралтай, боловсролтой, чинээлэг ээж нь хүүдээ сонгодог боловсрол олгуулахыг эцэг Жозеф Хёрстоос байнга шаарддаг байв. Ирээдүйн хэвлэлийн хааны эцэг нь алт олборлогчоор амиа зогоож эхлээд, асар их хөрөнгө хуримтлуулсан, санхүүгийн аз өрсөн заль мэхэнд оролцдогоороо алдаршсан, хамаг хөрөнгөөрөө дэнчин тавихаас буцдаггүй гэгддэг нэгэн байжээ. Залуу Хёрст энэ бүх чанарыг эцгээсээ өвлөжээ. Хожим тэрээр эцгээсээ дутахгүй бизнесмен гэдгээ дэлхий дахинд харуулахад чухам эдгээр чанар л түүнд юу юунаас хэрэг болсон байна.

Уилли (ирээдүйн магнатыг эцэг, эх нь ийн өхөөрдөн дууддаг байжээ) чөлөөт цагаараа ан хийх, загасчлах, морь унах зэргээр зугаацаж, бага насаа Сан-Франциско хотод өнгөрөөжээ. Тэндхийн сургуульд ганц хоёр жил суралцсан Уиллиг ээж нь ятгасаар байгаад Америкийн зүүн хэсэгт орших Нью-Хэмпшир муж дахь Конкорд хотын Ариун Павлын хувийн сургуульд явуулсан байна. Дунд сургуулиа дүүргээд, Уилли мөн л ээжийнхээ зөвлөсний дагуу их сургуульд орж, дөрвөн жил суралцжээ. Чухам тэр үед түүний сэтгүүлчийн авьяас тодорч, сургуулийнхаа «Гарвард Лампун» сонины эрхлэгч болж, энэ салбарт багагүй амжилтанд хүрсэн аж.

1884 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Уилли хэн болохоо олон түмэнд, үгүй гэхэд их сургуулийнхандаа харуулжээ.

«Гарвард Лампун»-ы сурталчилж байсан Гровер Кливленд сонгуульд ялалт байгуулсныг Уильям сургуулийнхаа хэмжээнд дэндүү сүр дуулиантай тэмдэглэсний улмаас захиргаа түүнийг хэсэг хугацаанд хичээлдээ явахыг хориглосон байна. Кливлендыг Ерөнхийлөгчээр сонгогдоход шууд нөлөөлөөгүй ч тодорхой хэмжээгээр гар бие оролцсондоо Уильям урамшиж, угаасаа ч сургууль соёлд дургүй байсныг хэлэх үү, сэтгүүлч болохоор хатуу шийджээ. Тэрээр голын цаахна талд орших Бостон хотын сонинуудыг их сонирхох болов. Сурлага хичээлээсээ улам хөндийрч эхэлсэн Уильямыг Гарвардын удирдлага 1886 онд хассан байна.

Тэр үеэр эцэг Жорж Хёрст Калифорнийн их хурлын доод танхимд сонгогдоод, бүрэн хугацаагаар ажиллаж, үүний дараа АНУ-ын Сенатад сонгогджээ. Кливлендыг нэр дэвшүүлсэн ардчилсан намыг их хэмжээний мөнгөөр санхүүжүүлдэг Жорж, хүүгээ 1887 онд Сан-Францискод эргэж ирэхэд өрөнд баригдсан «Икзэминер» сониныг худалдан авч өгч, бяцхан бэлэг барьсан аж.

Уильям сонины эзэн болоод, юуны түрүүнд анхны «хэвлэлийн хаан» цолыг хүртсэн Жозеф Пулитцерийн арга барил, эрхлэн гаргадаг «Нью-Йорк Уорлд» сониныг нь иж бүрэн судалжээ. Сэтгүүл зүйд анхны алхамаа хийж байсан Пулитцерийг бодвол Хёрст тэс өөр байсан юм. Саятан эцэг, эхээрээ хязгааргүй санхүүжүүлдэг Уильям, Пулитцер шиг бүхнийг тэгээс эхлээгүй, мөнгөний хувьд гачигдалтай зүйл байсангүй. Авьяаслаг редактор, сурвалжлагчдыг өндөр үнээр

хөлслөх болсон Хёрстын «Икзэминер» удалгүй өөрийн уншигчидтай болов. Пулитцерын адил Хёрст нийгмийн хор уршгийг эрс хатуу шүүмжилж эхлэв. Өөрийгөө радикал ардчилсан үзэлтэн гэж зарласан Хёрст сониноо мөнгө хайрлалгүй сурталчилж, амжилтанд хүрчээ. Ялангуяа, Өмнөд Номхон далайн төмөр замын компани улсын мөнгийг идэж завшсан, хээл хахууль, авилгалд автсан, ард түмний эрх ашгийг гаргуунд нь хаясан гэдгийг нотолж чадсан нь «Икзэминер»-ийн нэр хүндийг огцом өсгөжээ.

Таван жил шаргуу хөдөлмөрлөсний эцэст Хёрст сониныхоо хувийг 25 мянгаас 80 мянга болтол нь өсгөж чадсан байна. «Икзэминер» орлогынхоо хувьд Баруун мужуудад нэгдүгээр, АНУ-д хоёрдугаар байранд орлоо. Гэвч энэ бүхэн Хёрстын хувьд дөнгөж эхлэл байлаа.

«Нью-Йорк Жорнэл»

Хёрст Америкийн хэд хэдэн томоохон хотод сонинтой болж, гинжин хэлхээ байгуулахыг хүсч байлаа. АНУ-ын төмөр замын газрын зураг дээр ирээдүйн хэвлэлийн хаан гол хотуудын улаанаар тойруулаад, хэзээ нэгэн өдөр эдгээр газар миний сонинууд гарах болно гэж редакторууддаа мэдэгдэв.

Тэрхүү зураг дээр Нью-Йоркийг давхар зурсан байв. Хёрстын хувьд энэ аварга хотыг байлдан дагуулах нь эрхэм зорилго байлаа. Байр сууриа хэдийнэ олсон Пулитцерийн «Нью-Йорк Уолд»-той халз тулалдахын тулд асар их хөрөнгө шаардлагатай байв. Урьдын адил санхүүжүүлдэг ээж нь Уиллидээ 7,5 сая доллар өгчээ.

Ингээд 32 настай Хёрст Нью-Йоркд ирж, «Нью-Йорк Ворлд» сонины редакци байрладаг хотын хамгийн өндөр барилгыг хараад, заавал давж гарна гэж өөртөө тангараг өргөжээ. 1895 онд Хёрст 180 мянган доллараар агуу Жозеф Пулитцерын дүү Альбертын эзэмшдэг, нэг центээр ширхэг нь борлогддог өдөр тутмын «Морнинг Жорнэл»-ыг худалдан авсан байна. Маргааш нь Хёрст ээжийнхээ мөнгийг шууд эргэлтэнд оруулж, сониноо гар татахгүй сурталчилж, Пулитцерын шилдэг сурвалжлагчид, редакторуудыг хамаагүй илүү шагнал, урамшуулал амлаж, өөрийн талдаа татаж эхэлжээ. Хэдэн зуун мянган доллар шинэ технологи, тоног төхөөрөмжинд зарцуулагдав. Ээжээсээ авсан, мөн өөрт нь байсан тэр бүх мөнгө дуусдагийн даваан дээр «Морнинг Жорнэл» дөнгөж ашиг өгч эхлэв.

Шинэ өрсөлдөгчийнхээ үйл ажиллагааг анхнаас нь гярхай ажиглаж эхэлсэн Пулитцер Хёрстыг эцэг эхийнхээ мөнгөөр тоглосон хөнгөмсөг залуу гээд, 6 сарын дараа дампуурна гэжээ³. Гэвч зөгнөж хэлсэн болгон нь биелдэг Пулитцер энэ удаад алдсан байна. Зургаан сар өнгөрөхөд Хёрстын «Жорнэл» дампуурсангүй, харин ч эрч хүчээ авч эхлэв. «Жорнэл» Нью-Йоркийн зах зээлийг хязгааргүй эзэмшсэн «Уорлд»-той тулалдаж чадахаа хүн бүхэнд харууллаа.

«Жорнэл»-д Пулитцерын зарим шилдэг сэтгүүлч, тухайлбал, ням гаригийн «Санди Уорлд»-ыг бүтээлцсэн Моррил Годдард, нэрт тоймч Артур Брисбен нар «урвав». Тэдний эгнээг Хёрст «Сан-Франциско Икзэминер»-ийн шилдгүү-

дээр зузаатгажээ. Хёрст ямар нэг шинэ зүйл бүтээхийг хүссэнгүй. Харин Пулитцерын арга барилыг тэр чигээр нь хуулбарлажээ.

Хёрст «Уорлд»-ын нэг ч буланг орхисонгүй. Аажимдаа «Жорнэл» «Уорлд»-ын төрхийг олжээ. Гэхдээ Хёрст Пулитцерын жоруудыг илүү эрчтэй, зоригтой хэрэгжүүлж эхэлсэн байна. Улс төрийн ба гэмт хэргийн мэдээллийг тэнцвэртэй барих анхны бодлогоосоо Хёрст удалгүй бүрмөсөн татгалзаж, хоёр дахь чиглэлийг барив. Тэр дотроос сексийн шинжтэй гэмт хэргийг түлхүү тусгаж байлаа. «Жорнэл»-ын дугаарууд «Дөрвөн эхнэртэй байжээ», «Тэр бүсгүй үхлийн харайлт хийв», «Их бууны суманд оногдож алагджээ», «Амьдаар нь оршуулав», «Үхлийг баримтлагч» зэрэг нийтлэлээр дүүрэв.

Пулитцерын адил Хёрст эмэгтэйчүүдийг татахын тулд багагүй зүтгэжээ. Янз бүрийн зөвлөгөө, хов жив, дээдсийн амьдрал эмэгтэйчүүдэд зориулсан нүүрүүдийг баттай эзлэв. Спорт, гадаад болон дотоод мэдээ, газар усны гамшгийн тухай хачирласан материалууд гяланцаг гарчиг, зургийн хамт дугаар болгонд нийтлэгдэж байв.

«Санди Жорнэл»

Хёрст сенсаци т сэтгүүл зүйг амралтын өдрийн дугаар «Санди Жорнэл»-д сонгодог утгаар нь хэрэгжүүлсэн гэж судлаачид үздэг. Хэний ч бичиж зүрхэлдэггүй тийм найруулгаар Хёрстын сонинууд бичигддэг байв. Амралтын өдрийг ихэнх нь-йоркчууд өөрсдийгөө зугаацуулах зүйлгүй гэртээ өнгөрөөдгийг анхааралд авсан Хёрст 1897 оны хавар гэхэд

гурван хавсралттай, нийт 80 нүүр бүхий «Санди Жорнэл»-ээ тэдний гар дээр тавьжээ. Энэхүү гурван хавсралт нь «Америкэн Мэгэзин», «Америкэн Уимин'з Хоум Жорнэл», «Америкэн Хьюморист» байлаа.

Хёрстын сэтгүүлчдийн гараас гарсан гэмт хэрэг, секс, аваар осол, гал усны гамшиг, дайн, шинжлэх ухааны ололт нээлт гээд тал бүрийн мэдээлэл бүгд уншаад эхэлвэл хойш тавимгүй тийм сонирхол татсан найруулгаар бичигддэгээрээ алдаршжээ.

Пулитцерыг дагаад Хёрст дундад ба ажилчин ангийнхны эрх ашгийг хамгаалж, нийгмийн тусын тулд «тарган трестууд»-тэй тэмцэх болов. Нью-Йоркийн Хийн трест, Үндэсний Сахарын синдикат зэрэг монополь байгууллагуудын булхайг илчилснээр «Жорнэл» байр сууриа улам бататагаж чаджээ. Ажилчин ангийнханд Хёрст олон тус хүргэсний нэг нь Бруклины ачигчдад ажлын өдрийг багасгахад нөлөөлсөн явдал байлаа.

АНУ-Испанийн дайн ба «Жорнэл»

АНУ-Испанийн дайн бол сенсацийн сэтгүүл зүйн оргил байлаа. Энэхүү анхны империалист дайныг гарахад хамгийн гол үүргийг гүйцэтгэсэн хүн бол Хёрст байсан юм. Олон жил Испанийн талхинд байсан Кубад колоничлогчдын эсрэг бослого гарахад тус арлыг АНУ-д нэгтгэх таатай шалтаг гарлаа гэж үзсэн урсгал Америкт

хүчтэй байв. Энэ урсгалыг Пулитцер, Хёрст нар дэмжиж байжээ. Тэдний гол зорилго нь Кубад Испанийн дарангуйллыг зогсоож, энх тайвныг тогтоохын тулд АНУ Испанид дайн зарлах ёстой гэсэн үзлийг олон нийтэд төрүүлэх байлаа.

Хёрст сониныхоо нэрд гарсан хослол — сурвалжлагч 32 настай Ричард Хардинг Дэвис, зураач 35 настай Фредерик Рэмингтон нарыг тусгай даалгавартай Куба руу илгээсэн байна. Эзнийхээ хувийн хөлгөөр очсон тэд тэр даруй «Оливеттын хэрэг» гэгчийг «илрүүлжээ».

Дэвисийн бичсэнээр, цэрайлаг, боловсролтой, залуухан америк бүсгүйг «Оливетт» хөлөг онгоцон дээр бүдүүлэг испаничууд нүцгэлэн, эрээ цээргүй нэгжсэн байна. Рэмингтон сэдэвт нь тохируулж, испаничуудын дунд зогсож буй нүцгэн бүсгүйг дүрсэлжээ. Энэ нийтлэл аянгын

«

Хёрст түүхэнд үлдсэн «Танаана үлдэх хэрэгтэй. Бидэнд зовхон зураг л илгээ. Дайныг нь би хийе» гэсэн гуравхан өгүүлбэртэй захиа алдарт захиагаар хариу барьжээ.

»

эхлэл байлаа. АНУ-ын Конгрессын хурал дээр сенатч Кэмерон энэ асуудлыг албан ёсоор тавив. Гэтэл Пулитцерын «Уорлд»-ын сэтгүүлчид мөнхийн өрсөлдөгчөө дарахын тулд өнөөх бүсгүйг олж уулзаад, «Жорнэл»-д нийтлэгдсэн материал ор үндэсгүй болохыг мэдэгджээ.

Аргаа барсан Рэмингтон эзэндээ цахилгаан илгээж, испаничуудын нэрийг хугалах материал олдохгүй байгааг мэдэгдээд, Нью-Йоркдоо эргэж ирэх хүсэлтэйгээ илэрхийлжээ. Хёрст түүхэнд үлдсэн алдарт захиагаар хариу барьжээ.

«Та наана үлдэх хэрэгтэй. Бидэнд зөвхөн зураг л илгээ. Дайныг нь би хийе»⁴ гэсэн гуравхан өгүүлбэртэй захиа алдарт Гай Юлий Цезарийн «Ирлээ. Үзлээ. Яллаа.» хэмээх домог болсон хэллэгээс ялгаагүй байв.

Энэ үед «Жорнэл»-ын хувь эрс өсөв. 1896 оноос гаргаж эхэлсэн оройн «Ивнинг Жорнэл» 407 мянган хувь болов. 1896 оны 11-р сар гэхэд өглөөний ба оройн дугаар нийтдээ 1 сая хувиар борлогдож байжээ. Түүнээс гадна амралтын дугаар 500 мянган хувиар тараагдаж байв.

1897 оны турш, 1898 оны эхний 4 сарын турш «Жорнэл» Кубын сэдвийг дэндүү идэвхтэй тусгаж байлаа. «Оливеттын хэрэг»-ийн дараа «Руисийн хэрэг» гэгч «Жорнэл»-ын нүүрээс салахаа болив. Шүдний эмч Рикардо Руис бол 1868-1878 онд Испанийн эсрэг бослогод ороолцож байгаад, АНУ-д ирж суурьшаад, тус орны иргэн болсон нэгэн аж. Хэдэн жилийн дараа Руис Кубадаа эргэж ирээд, энгийн ажлаа эрхлэх болжээ. 1897 оны эхээр түүнийг Испанийн цагдаа нар хотын трамвайд хулгай хийсэн хэргээр баривчилж, тэрээр удалгүй шоронгийн өрөөндөө амьтавьсан байна. Чухам яагаад нас барсан нь тогтоогдоогүй байхад «Жорнэл» 1897 оны 2-р сарын 20-ны дугаартаа «Америкийн иргэнийг Испанийн шоронд хөнөөв» гарчигтай том материал нэгдүгээр нүүрэндээ нийтэлж, Руисийг испаничууд алсан гэсэн хөдөлшгүй баримт бий тухай мэдээлжээ.

Гэвч энэ бол эхлэл байлаа. Хэдэн сарын дараа «Сиснеросын хэрэг» дэгдэв. Сөрөг хүчний засгийн газрыг толгойлсон,

Кубын босогчдын лидер, ерөнхрийлэгч Бетанкурын зээ охин Эвангелина Сиснеросыг амбан захирагч, хурандаа Беррисийг гэртээ урьж авчраад, босогчдоор алуулсан хэрэгт испаничууд буруутгаж, хорьжээ. Харин «Жорнэл» 1897 оны 8-р сарын 17-ны дугаартаа тэс өөр зүйл өгүүлэв. Тухайлбал: Сиснеросын гоо сайханд хөл алдсан Беррис түүнийг биеэ тушаахыг удаа дараа шаардсанд шударга журамт бүсгүй айж, найз нөхөддөө хэлэхэд тэд нүгэлт амбан захирагчийг хороосон гэжээ. Мэдээж, энэ бүхнийг тун сэтгэл хөдөлгөм өгүүлж, испаничуудыг араатан мэт дүрсэлжээ. Испаничууд Сиснеросыг шоронд хориход «Жорнэл» бөөн шуугиан дэгдээв. Үүний үр дүнд зуу зуун америк эмэгтэй бухимдлаар дүүрэн, дургүйцлээ илэрхийлсэн захиаг Куба дахь Испанийн төлөөлөгчийн газар илгээжээ. Сиснерос шоронд хэдэн сар болоод тун ч гайхалтай аргаар суллагдсан байна. «Жорнэл»-ын сэтгүүлч Карл Деккер Сиснеросын хоригдож байсан шоронд хажуугийн байшингийн дээврээр дамжиж очиж, торон цонхыг хөрөөдөж, куба бүсгүйг чөлөөлжээ.

«Жорнэл»-ын 10-р сарын 10-ны дугаар «Америкийн сонин шилдэг дипломатчдын олон сарын үргүй хоосон оролдлогыг гэтэлж, хүчирхэг цохилт өгөв» гэсэн том гарчигтай (мэдээж, тэргүүн нүүрэндээ) нийтлэгдсэн байна. Гэвч Сиснеросын хэрэг үүгээр өндөрлөсөнгүй. Сиснеросыг Нью-Йоркод хувийн хөлгөөр нь ирэхэд хэвлэлийн магнат өөрөө угтаж, Мэдисон Сивер Гарденд тансаг хүлээн авалт хийж, дээдсийн «Дельмонико» ресторанд үргэлжлүүлэв. Үүний дараа Хёрст

куба бүсгүйг Цагаан ордонд аваачиж, Ерөнхийлөгч Мак-Кинлитэй хүртэл уулзуулжээ. «Жорнэл»-ын маргаашийн дугаар нэгдүгээр нүүрэндээ АНУ-ын Ерөнхийлөгчтэй гар барьж буй Сиснеросын том гэгчийн зурагтай хэвлэгдсэн байна. «Хатагтай Сиснерос шоронд орохоосоо өмнө ба 15 сарын дараа» зураг олны жигшилд зэвүүцлийг хүргэв. Нэг зурган дээр царайлаг куба бүсгүй, нөгөө зураг дээр ядарч сульдсан эмэгтэй дүрслэгджээ. Америк даяар зэвүүцэж, испаничуудыг буруушаан эсэргүүцэж байлаа.

Хёрстод одоо өөр, дипломат «хэрэг» шаардлагатай болов. Эзэн хичээвэл заяа хичээнэ гэгчээр «Де Ломегийн хэрэг» өөрөө «гараад» ирэв. Кубын Хунтын (Нью-Йоркд байрладаг босогчдын бүлэг) гишүүн Гавана дахь шуудангийн

газраас Испаниас АНУ-д суугаа элчин сайд Дюпуи Де Ломегийн бичсэн захиаг олжээ. Тэрхүү «гишүүн» үнэн хэрэг дээрээ Хёрстын туршуул байсныг хэлвэл тус захиаг олсон биш, харин «олсон» нь тодорхой. Де Ломе энэ захиагаа яагаад дипломатын шуудангаар илгээгээгүй нь ойлгомжгүй. «Эль Эральдо де Мадрид» сонины редактор Хосе Каналихас-и Мендес де Ломе «бичихдээ» АНУ-ын Ерөнхийлөгчийг «овоорсон хүмүүст хөтлөгдөж явдаг авьяасгүй лүд» гэжээ. Де

Ломегийн «захиа»-г нийтэлсэн нь гал дээр тос хийв. Эрх чөлөөний орны иргэдийг «овоорсон хүмүүс», Ерөнхийлөгчийг «авьяасгүй лүд» гэнээ? Америкийн гуйлгачин нь хүртэл Де Ломег хөөхийг шаардаж байлаа. Гэвч «захиа» нийтлэгдсний нөгөөдөр нь Де Ломе сайн дураараа огцорсон аж.

Одоо Хёрстод эцсийн цохилт хэрэгтэй байлаа. Эрсэн хүн олно гэгчээр «Мэйн»-ий хэрэг» гарав. Гаванад бослого гарахад тэнд амьдардаг америкчуудын амь нас, эд хөрөнгийг хамгаалуулахаар байлдааны «Мэйн» хөлгийг АНУ-ын Засгийн газар илгээсэн нь 1898 оны 1-р сарын 24-нд очжээ. Гэвч 2-р сарын 15-нд Гаваны боомтод «Мэйн» дэлбэрч, 260 цэрэг амиа алджээ. «Жорнэл»-ын гарчиг энэ үеэр хэм-

«

АНУ-ын Засгийн газар дэлбэрэлтийн шалтгааныг тогтоох комисс томилсон ч «Жорнэл»-ын сэтгүүлчид тэднээс урьдчилаад, нууц баримт бичгүүдийг «илрүүлжээ». Тухайлбал: «Мэйн»-ий ахмад Сигзбигийн «нэг л сэжигтэй байгаа» талаар захиа «олджээ». Хёрст энэ бол сүүлчийн цохилт гэдгийг ойлгож байлаа.

»

жээний хувьд улам томров. АНУ-ын Засгийн газар дэлбэрэлтийн шалтгааныг тогтоох комисс томилсон ч «Жорнэл»-ын сэтгүүлчид тэднээс урьдчилаад, нууц баримт бичгүүдийг «илрүүлжээ». Тухайлбал: «Мэйн»-ий ахмад Сигзбигийн «нэг л сэжигтэй байгаа» талаар захиа «олджээ». Хёрст энэ бол сүүлчийн цохилт гэдгийг ойлгож байлаа. «Жорнэл» гэмт хэрэгтнийг илчилсэн хүнийг 50 мянган доллараар урамшуулахаа амлаж, амь үрэгдсэн

хүмүүст зориулж, дурсгалын хөшөө барих ажлыг эхлэв.

Дайн ойртож байлаа. Ерөнхийлөгч Мак-Кинли Кубын асуудлыг дипломат аргаар зохицуулахыг оролдсоныхоо хариуд эрс хурц шүүмжлэлтэй тулгарчээ. Америк даяар Испанитай дайтаж, Кубын ард түмнийг «чөлөөлөхийг» шаардаж байв. 1898 оны 4-р сарын 17-нд АНУ Испанид дайн зарлав. «Жорнэл»-ын хувь 1,5 сая болтлоо огцом өсөв.

«Ж» орнэл»-ын сэтгүүлчид Америкийн арми, флотыг хаа явсан газар нь дагалдаж, дайны талбараас хамгийн халуун мэдээг дамжуулж байлаа. Дөрвөн сар үргэлжилсэн дайнд Хёрст 500 мянган доллар зарцуулсан ч тэр зардлаа хэд дахин нугалжээ. «Жорнэл» дайны ид оргил үеэр өдөрт 40 хүртэл удаа (!) хэвлэгдэж байлаа. АНУ-Испанийн дайнаар Хёрстын 35 жил үргэлжилсэн ганцаарчилсан хаанчлал эхлэв. Юм бүхний түрүүнд байдаг «Жорнэл» Испанитай байгуулсан энхийн гэрээг албан ёсоор зарлахаас нь өмнө бүрэн эхээр нь хүртэл олоод нийтэлсэн нь хачирхалтай. Дайны үр дүнд АНУ Испаниас Куба, Пуэрто-Рико, Филиппин, Гуам, Гавайн арлуудыг салган авчээ. Харин Хёрст хэвлэлийн шинэ хаанаар өргөмжлөгдөж, хамгийн том өрсөлдөгч Пулитцерээ давж гарчээ.

Дайн дууссаны дараа «Жорнэл» зүгээр суусангүй. Бүгд найрамдах намаас нэр дэвшсэн Ерөнхийлөгч Мак-Кинлиг «трестуудыг ивээн тэтгэгч» гээд, ээлжит загалмайтны дайнаа эхлэв. «Муу хүнийг алж байж л түүнээс салдаг бол түүнийг алах хэрэгтэй» гэж «Жорнэл» XX зууны

эхэнд бичиж байжээ. 1901 онд Ерөнхийлөгч Мак-Кинли алагдсан байна. Алуурчны халааснаас «Жорнэл»-ын дугаар олджээ. XX зуун дөнгөж эхэлж байлаа...

Хёрстын сонины гинжин хэлхээ оноос онд баяжиж байв. 1933 он гэхэд Хёрстын хэвлэл дээд оргилдоо тулжээ. Энэ үед Хёрстын нэгдэл 26 өдөр тутмын, 17 долоо хоног тутмын сонин, 12 сэтгүүл, 2 кинокомпанийг эзэмшиж байлаа. Дараагийн жилүүдэд Хёрстын эзэнт улс байр сууриа шинэ өрсөлдөгчдөд алдаж эхэлжээ. Гэхдээ л 1955 онд Хёрст нас барахдаа өв залгамжлагч нартаа АНУ-ын өдөр тутмын сонины нийт хувийн 1/10-ыг эзэмшсэн трестийг үлдээжээ.

Бүх насаараа трестийн эсрэг тэмцсэн Хёрст өөрөө тресттэй байсан нь сонирхолтой.

Хёрстын өв

Хёрст Америкийн сэтгүүл зүйн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсныг түүний хийсэн сөрөг үйлдлүүдээр дарж хэрхэвч болохгүй.

Эерэг тал нь гэвэл:

1. Тэрээр өглөөний, оройн, амралтын сониныг илүү уншвартай, илүү сонирхолтой болгосон.
2. Тэрээр сонины чимэглэлийг сайжруулж, том гарчиг нэвтрүүлсэн.
3. Тэрээр эрх мэдэлтнүүдийн эсрэг хэд хэдэн илчлэх кампанит ажиллагаа явуулсан.
4. Тэрээр шинжлэх ухааны ололт амжилтыг өргөн дүүрэн сурталчилж байсан.
5. Тэрээр дундад ба ажилчин ангийнхны эрх ашгийг хамгаалдаг байсан.

6. Тэрээр сэтгүүлчдийнхээ ахуй байдалд ихээхэн анхаарал тавьж, цалинг эрс нэмсэн.

Сөрөг тал нь гэвэл:

1. Түүний сэтгүүлчид шуугиан дуулианы араас хэт хөөцөлдөж, үйл явдлын цар хүрээг зохиомлоор дэврүүлж байсан.
2. Түүний сэтгүүлчид үйл явдлыг зохиож, өөрт ашигтайгаар гуйвуулж байсан.
3. Тэрээр гэмт хэрэг, секс хоёрт түлхүү анхаарч байсан.
4. Түүний гарт сонин мэдээллийн бус, зугаа цэнгээний хэрэгсэл болж хувирсан.
5. Тэрээр АНУ-Испанийн дайн гарахад нөлөөлсөн.

Хёрст сонинуудаараа олон нийтийн эрх ашгийг хамгаалахын зэрэгцээ тэдний үзэл бодлыг удирдаж, чиглүүлж байв. Уильям Хёрст ард түмнээ ч мартдаггүй, ашиг хонжоогоо ч мартдаггүй, эсрэг тэсрэгийг хослуулж чадсан хэвлэлийн хаанаар түүхэнд үлдсэн юм.

Ишлэл

1. Малаховский А.К. 1997. Очерки истории журналистики США второй половины XIX в. М. С. 31.
2. Беспалова А.Г., Корнилов Е.А., Короченский А.П., Лучинский Ю.В., Станько А.И. 2000. История мировой журналистики. Изд. 2-е. Ростов-на-Дону. С. 134.
3. Мкртчян А.А. 1995. Пособие по курсу «История журналистики США XVIII-XIX вв.». М. Изд-во Росс. Ун-та дружбы народов. С. 39.

4. Schudson M. 2001. Discovering the News. P. 61-62.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Беспалова А.Г., Корнилов Е.А., Короченский А.П., Лучинский Ю.В., Станько А.И. 2000. История мировой журналистики. Изд. 2-е. Ростов-на-Дону.
2. Лучинский Ю.В. 1996. Очерки истории зарубежной журналистики. Краснодар.
3. Малаховский А.К. 1997. Очерки истории журналистики США второй половины XIX века. Журналистика «позолоченного века». М. Изд-во Росс. Ун-та дружбы народов.
4. Мкртчян А.А. 1995. Пособие по курсу «История журналистики США XVIII-XIX вв.». М. Изд-во Росс. Ун-та дружбы народов.
5. Тодоров Д. 1977. Чуждестранна журналистика. София.
6. Kobre S. 1970. Foundation of American Journalism. N.Y. Westpoint.
7. Schudson M. 1978. Discovering the News. A Social History of American Newspapers.